



СЭЛЭНГЭ АЙМАГ
САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 28 өдөр

Дугаар 073

Цагаантолгой

Санал эрэмбэлэх ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, Төсвийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.3, 66 дугаар зүйлийн 66.1.1 дэх заалтууд, Сангийн сайдын 244 тоот тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2023 онд хэрэгжүүлэх төслийн саналыг эрэмбэлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч- Б.Мөнх-Эрдэнэ-(сумын Засаг даргын орлогч)

Нарийн бичгийн дарга- Г.Ууганцэцэг- (Санхүү албаны дарга)

Гишүүдэд- А.Батдорж- (БОХУБ)


З.Цолмон- (ХАА-н тасгийн дарга)

З.Оюунсүрэн- (ХЖДҮХХМ)

Ж.Оюунбат-(Иргэний төлөөлөл)

М.Эрхэмзаяа-(Иргэний төлөөлөл)

2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2023 онд хийгдэх төслийн саналыг “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын дагуу эрэмбэлэн холбогдох материалуудыг бүрдүүлж “сумын Иргэдийн төлөөлөгчдийн хуралд танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Мөнх-Эрдэнэ)-д даалгасугай.



С.ШИЖИРБААТАР

Боловсруулсан: *С. Рагавдор*

Хянасан: *С. Шинэбаяр*

Хувь: *2*

Огноо: *2022 03 20*